



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 9/230

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Наурызын баярыг тохиолдуулан Хэрлэн сумын Казак ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэхэд 1,750,000 (нэг сая долоон зуун тавин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 14-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зарцуулалтын тооцоо

№	Материалын нэр	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Материалын үнэ	1	1750000
	Нийт		1750000